




ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ АЙМГИЙН ТООЛЛОГЫН НЭГДСЭН ДҮН

/Хураангуй/



Өмнөговь аймаг
2020 он

АГУУЛГА

1. ХҮН АМ	4
2.ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА	4
3. ШАШИН	5
4.ХҮН АМЫН СУУРЬШИЛ.....	5
5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН.....	6
6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ.....	7
7.ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ.....	8
8.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ.....	9
9.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ.....	11
10.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ	12
11. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД	15
12. СУУЦНЫ НӨХЦӨЛ.....	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР.....	4
ХҮСНЭГТ 2. МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР 2010 2020ОН.....	6
ХҮСНЭГТ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	6
ХҮСНЭГТ 4. ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР 2010, 2020 ОН.....	7
ХҮСНЭГТ 5.ХҮН АМЫН ТОО,НЯГТРАЛ, СУМ,ХУВИАР, 2010,2020 ОН.....	7
ХҮСНЭГТ 6. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	8
ХҮСНЭГТ 7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, СУМ, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	11
ХҮСНЭГТ 8. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН.....	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.1 АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО 2010 ОН.....	4
ЗУРАГ 1.2 АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО 2020 ОН.....	5
ЗУРАГ 2 ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ТОО ХУГАЦААГААР 2010 2020 ОН	8
ЗУРАГ 3.1 ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН.....	9
ЗУРАГ 3.2 ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН.....	10
ЗУРАГ 4. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС 2000 2010 2020 ОН	10
ЗУРАГ 5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН.....	11
ЗУРАГ 6. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	12
ЗУРАГ 7. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН.....	12
ЗУРАГ 8. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВРАГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН.....	13
ЗУРАГ 9.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2010 ОН.....	13
ЗУРАГ 9.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН.....	14
ЗУРАГ 10. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС ХУВИАР 2020 ОН.....	14
ЗУРАГ 11. ГАДААДАД ОРШИН СУУГАА ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН УЛСААР, 2020 ОН.....	15
ЗУРАГ 12. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН.....	16
ЗУРАГ 13. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН.....	17

1. ХҮН АМ

Өмнөговь аймгийн хүн ам 69187, өрхийн тоо 21106 болсныг тоолж гаргалаа.


Хүн амын тоо 2010-2020 оны хооронд жилийн дундаж өсөлт өмнөх тооллогоос 1.4 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР


Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа	Хүн амын жилийн дундаж өсөлт хувиар
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		
1956	20173	9095	11078	82.1	-
1963	22785	10793	11992	90	1.8
1969	26390	12664	13726	92.3	2.5
1979	32865	16043	16886	95	2.2
1989	42445	20793	21652	96	2.6
2000	46858	23488	23370	100.5	0.9
2010	61314	35137	26177	134.2	2.8
2020	69187	34653	34534	100.3	1.4

Өмнөговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт нь 2010 оныхоос 1.4 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 1.1 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО, 2010 ОН



ЗУРАГ 1.2 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Өмнөговь аймгийн хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа ба 0-14 насны хүүхэд 31.9 хувь, 15-64 насны хүн ам 64.3 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 3.8 хувь эзэлж байна.

Хүйсийн харьцаа өмнөх тооллогын үетэй харьцуулахад 103.7 болж 30.6 пунктээр буурчээ. Мөн хүйсийн харьцаа нь 10, түүнээс дээш насны бүлэгт буурч байгаа нь эрэгтэйчүүдийн дунд нас баралт харьцангуй илүү байдагтай холбоотой.

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа голч нас 27.4 болсон нь хүн амын тэн хагас нь 27.4-өөс доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна. Нийт хүн амын 0.09 хувь нь буюу 594 мянган хүн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байна.

Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгч хүн амын тоо 55.4 байна. Хүн ам зүйн ачаалал 2020 онд 2010 оноос 13.4 пунктээр өссөн.

Хүн ам зүйн цонх үеийг ашиглан урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар улс орны нийгэм, эдийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлөх юм.

2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг өмнөх тооллогод 29 бүлгээр цуглуулж байсныг Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор 31 болгож өргөжүүлсэн.

ХҮСНЭГТ 2. МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР 2010, 2020 ОН

Үндэс угсаа	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
Монгол улсын харьяат -Бүгд	56 930	100.0	68 593	100.0
Халх	56 095	98.5	67 680	98.6
Дөрвөд	192	0.3	140	0.2
Буриад	123	0.2	142	0.2
Баяд	132	0.2	113	0.1
Бусад	388	0.7	1265	0.9

¹Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Монгол Улсын харьяат суурин хүн амын 98.6 хувийг халхчууд эзэлж, өмнөх тооллогоос 1.0 пунктээр өссөн байна. Бусад угсаатнуудын эзлэх хувийн жин 0.9 хувь байгаа нь халхчуудын дараа орж байна. Харин Дөрвөд, Баяд угсаатнууд 2010 оноос буурсан ба Буриад угсаатнууд ижил байна.

3.ШАШИН

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 52.7хувь нь шашин шүтдэг, 47.3 хувь нь шашин шүтдэггүй гэж тоологдлоо. Шашин шүтлэгтэй хүмүүсийн 89.2 хувь нь буддын шашинтан байна. Хүн амын дийлэнх нь буддын шашинтан боловч насны бүлгээр авч үзэхэд 15-19 насны өсвөр үеийнхний хувьд христ, бөө шашинтан олонх байна.

ХҮСНЭГТ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Шашны төрөл	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Шүтдэггүй	51.4	58.3	41.3	47.3	49.3	46.0
Шүтдэг	48.6	41.7	58.7	52.7	50.7	64.0
Будда	89.8	37.3	52.9	89.2	89.1	89.2
Ислам	0.2	2.1	3.8	0.1	0.1	-
Бөө	3.6	0.1	0.1	6.9	7.2	3.6
Христ	5.7	1.7	1.8	3.1	2.5	6.6
Бусад	0.7	0.4	0.2	0.7	1.1	0.6

3.ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Сумдын нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйгээс хамааран сумдын хүн амын суурьшил, нягтрал өөр өөр байгаа нь харагдаж байна. Энэ нь хүн амын суурьшил, нягтрал, хөгжлийн түвшин өөр өөр байгаагаас орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс болно.

Хүн амын суурьшлын ерөнхий дүр төрх өнгөрсөн тооллогоос ихээхэн өөрчлөгдсөн байна. Шилжих хөдөлгөөн, ялангуяа уул уурхайн нөлөөгөөр хүн ам Гурвантэс, Ханбогд, Цогтцэций Даланзадгад сумдад илүү байна.

ХҮСНЭГТ 4. ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР 2010,2020 ОН

Байршил	2010		2020	
	Хүн ам/мян.хүн/	Эзлэх хувь	Хүнам/мян.хүн/	Эзлэххувь
Хот	18 781	30.9	26 367	37.8
Хөдөө	42 074	69.1	43 491	62.2

Аймгийн хэмжээнд 2020 оны хотын хүн ам 2010 оны хотын хүн амаас 6.8 пунктээр өссөн бол хөдөөгийн хүн ам 6.9 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Өмнөговь аймагт сүүлийн 4 жилд төв суурин газарт суурьших үйл явц улам бүр нэмэгдсээр байна. Өмнөговь аймагт уул уурхайн үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимжсэн, хатуу хучилттай зам, төмөр зам гэх мэт дэд бүтэц сайтай, БНХАУ-тай хиллэдэг зэрэг нь аймгийн хотжих үйл явцад нөлөөлж байна.

ХҮСНЭГТ 5.ХҮН АМЫН ТОО,НЯГТРАЛ, СУМ, ХУВИАР, 2010,2020 ОН


Сумын нэр	2010			2020		
	Хүн ам	Дүнд эзлэх хувь	Хүн/км2	Хүн ам	Дүнд эзлэх хувь	Хүн/км2
БҮГД	60 855	100.0	0.4	69858	100.0	0.4
Даланзадгад	18 781	30.9	37.6	26367	37.7	52.3
Баяндалай	1 954	3.2	0.2	2091	2.9	0.2
Баян-Овоо	1 697	2.8	0.2	1886	2.6	0.2
Булган	2 036	3.3	0.3	2085	2.9	0.3
Гурвантэс	4 516	7.4	0.2	5101	7.3	0.2
Мандал-Овоо	1 581	2.6	0.2	1610	2.3	0.3
Манлай	2 031	3.3	0.2	2625	3.7	0.2
Ноён	1 017	1.7	0.1	1403	2.0	0.1
Номгон	2 710	4.5	0.1	2504	3.5	0.2
Сэврэй	1 891	3.1	0.2	2040	2.9	0.3
Ханбогд	9 662	15.9	0.6	8660	12.3	0.5
Ханхонгор	1 620	2.7	0.2	1984	2.8	0.2
Хүрмэн	1 564	2.5	0.1	1565	2.2	0.1
Цогт-Овоо	1 540	2.5	0.2	1818	2.6	0.3
Цогтцэций	8 255	13.6	1.1	8119	11.6	1.1

Даланзадгад, Баяндалай, Гурвантэс, Ноён, Манлай, Сэврэй сумдын хүн амын өсөлт нь уул уурхай илүү хөгжиж байгаатай холбоотой юм. Өмнөговь аймгийн хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 0.3 хүн ногдож байсан бол 2010 онд 0.4 хүн, 2020 онд 0.4 болж ижил түвшинд байна.

4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 9.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 30.6 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 2. ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ТОО, ХУГАЦААГААР, 2010, 2020 ОН



Сүүлийн 5 жилийн шилжих хөдөлгөөн аймаг, нийслэлийн хооронд 57.8 хувиар, сүүлийн 1 жилийн шилжих хөдөлгөөнд оролцогч 73.0 хувиар тус тус буурчээ.

5. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арав, түүнээс дээш насны хүн амын 94.5 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшсэн байна. Харин 15, түүнээс дээш насны хүн амын 99.1 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна.

ХҮСНЭГТ 6. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100	100	100	100	100	100
Боловсролгүй	8.1	7.5	8.8	5.5	5.8	5.2
Боловсролтой	91.9	92.5	91.2	94.5	94.2	94.8
Дээд	14.3	12.8	16.4	21.2	16.2	26.1
Тусгай мэргэжлийн дунд	4.6	3.7	5.9	4.2	3.8	4.7
Техникийн болон мэргэжлийн	3.4	3.2	3.8	4.8	5.4	4.3
Бүрэн дунд	25.2	27.4	22.1	25.1	26.0	24.1
Суурь	25.7	28.0	22.6	23.3	26.3	20.4
Бага	18.6	17.4	20.4	15.9	16.6	15.2

Боловсролын түвшин өмнө жилүүдээс харьцангуй өссөн ба бичиг үсэг мэддэггүй хүн амын түвшин буурчээ. Арав ба түүнээс дээш насны хүн амын дүнд бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь багассан байна. Харин дийлэнх нь буюу 25.1 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.

Нийт 10 ба түүнээс дээш насны хүн амын тоонд Монгол Улсад удаан хугацаагаар амьдарч байгаа гадаад улсын иргэдийг хамруулаагүй болно.

Дээд боловсролтой хүн амын түвшин өмнөх тооллогоос өссөн үзүүлэлттэй гарч байна. Арав ба түүнээс дээш насны суурин хүн амын 21.2 хувь нь дээд ба түүнээс дээш боловсролтой болсон нь 2010 оны үр дүнтэй харьцуулахад 6.9 пунктээр өссөн байна.

6. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өрхийн тоо 2010 оноос 29.2 хувиар өссөний дотор хотын өрх 31.1 хувиар, хөдөөгийн өрх 28.0 хувиар тус тус өссөн байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд 21106 өрх тоологдсоноос 65.1 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 13.0 хувь нь нийлмэл ам бүлтэй, 21.6 хувь нь ганц бие, 0.3 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.

Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод хөдөөгөөс 36.4 хувиар буурсан байна. Энэ нь төв суурин газарт орон сууцны хүрэлцээ хангамж тааруу, түрээсийн байрны хөлс өндөр, хөдөөгөөс шилжин ирэгчид хамаатан садантайгаа хамт амьдрах нь ихсэж байгаатай холбоотой юм. Ганц бие өрхийн тоо хотод өмнөх тооллогын үеийнхээс 2 дахин өссөнийг мөн шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болох юм.

ЗУРАГ 3.1 ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН




ЗУРАГ 3.2 ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Аймгийн хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 3.3 болсон нь 2010 оны улсын дундаж тоотой ижил байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 1-2 ам бүлтэй өрх хотод 5.3 пунктээр, хөдөөд 7.5 пунктээр өмнөх тооллогын дүнгээс нэмэгдсэн байна. Үүнийг шилжих хөдөлгөөн өөрөөр хэлбэл, хотод их, дээд сургуульд суралцагчид, болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирсэн хүмүүс тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой байж болох юм.

Хүн амын гэрлэлтийн байдалд огт гэрлээгүй хүмүүс өмнөх тооллогоос 4.8 пункт, гэр бүлтэй хүмүүс 4.6 пунктээр, харин цуцалсан хүмүүс 0.3 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 4. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, 2000, 2010, 2020




Анхны гэрлэлтийн дундаж наслалт эрэгтэйчүүдийн хувьд 2010 оны тооллогоос 1.3, эмэгтэйчүүдийн хувьд 3.4 өөр өссөн үзүүлэлттэй байна.

7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Аймгийн хэмжээнд 2020 онд 2026 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 2.9 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1099 буюу 54.2 хувь нь эрэгтэй, 927 буюу 45.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН



Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл хөдөлгөөний бэрхшээл 2010 оны тооллогоос 23.2 хувь, харааны бэрхшээл 38.0 хувь, сонсголын бэрхшээл 31.7 хувиар тус тус буурч, сэтгэцийн бэрхшээл 13.2 хувиар өссөн байна. Нийт бэрхшээлийн дийлэнх буюу 30.5 хувийг бусад (Хавсарсан болон бусад хөгжлийн бэрхшээлийг энд оруулав), 25.9 хувийг хөдөлгөөний бэрхшээл эзэлж байгаа бол хамгийн бага буюу 2.1 хувийг ярианы бэрхшээл эзэлж байна.

ХҮСНЭГТ 7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, СУМ, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Аймаг	2010 он		2020 он	
	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	Хүн амд эзлэх хувь	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	Хүн амд эзлэх хувь
Нийт	2183	3.6	2026	2.9
Даланзадгад	782	1.3	904	1.3
Баяндалай	107	0.2	104	0.2
Баян-Овоо	73	0.1	69	0.1
Булган	111	0.2	49	0.1
Гурвантэс	161	0.2	141	0.2
Мандал-Овоо	77	0.1	70	0.1
Манлай	105	0.2	87	0.1
Ноён	34	0.1	37	0.1
Номгон	102	0.2	82	0.1
Сэврэй	64	0.1	51	0.1
Ханбогд	159	0.3	97	0.1
Ханхонгор	78	0.1	78	0.1
Хүрмэн	59	0.1	68	0.1
Цогт-Овоо	78	0.1	52	0.1
Цогтцэций	193	0.3	137	0.2

Үйлдлийн чадвар

Насны бүлгээр авч үзэхэд 20-24 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн хамгийн их хүндрэл нь ой тогтоол/ санах байгаа бол 35-54 насныхны хувьд харааны болон алхах, харин 55 түүнээс насныхны хувьд алхах, өөртөө анхаарал тавих хүндрэлүүд байгаа нь нас ахих тусам эдгээр хүндрэл зонхилж байгааг харж болохоор байна.

ЗУРАГ 6. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



8. ИНТЕРНЕТ, ГЭР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор зургаа ба түүнээс дээш насны нийт суурин хүн амын 90.0 хувь нь гар утас хэрэглэж байгаа бол 69.3 хувь нь интернэт хэрэглэгчид байна.


Зургаа ба түүнээс дээш насны гар утас, интернэт хэрэглэгчдийн дүнд эзлэх хувь 2010 оноос харьцангуй өссөн ба гар утас хэрэглэгчид 12.1 хувиар интернэт хэрэглэгчид 46.3 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 7. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН



Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирснээр гар утас болон байнга интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна.


ЗУРАГ 8. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВРАГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ 2010, 2020 ОН




9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн насны буюу арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 65.7 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 9.0 пунктээр буурсан бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам (34.3%) 8.9 пунктээр өсчээ. Нийт хөдөлмөрийн насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 5.4 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 9.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2010 ОН




ЗУРАГ 9.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН



Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 40.2 хувь байгаа нь хотынхоос 24.6 пунктээр илүү байна.

Арван тав, түүнээс дээш настай нийт хүн амын 65.7 хувь нь ажил эрхэлж байхад энэ үзүүлэлт хөдөөд 68.6 хувь байгаа нь хөдөөгийн хүн амын дийлэнх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэгтэй холбоотой.

ЗУРАГ 10. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС ХУВИАР 2020 ОН



Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 4.0 хувь болж, өмнөх тооллогын үеийнхээс 8.3 пунктээр буурчээ. Ажилгүйдлийн түвшин хотод өндөр, хөдөөд бага байна. Энэ нь нэг талаас хот суурин бараадсан шилжих хөдөлгөөн их байгаа, нөгөө талаас тэд хотод шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой.


Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн дотор 25-34 насны 10570 залуучууд байгаа нь хамгийн их буюу нийт ажилгүй хүний 17.9 хувийг эзэлж байна. Харин 30-аас дээш насныханд эмэгтэйчүүд илүү их ажилгүйдэлд өртөж байна.

Аймгийн хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 16.3 мянга байгаа нь өмнөх тооллогоос 25.1 хувиар өссөн байна. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй, гэрийн ажилтай, тохирох ажил олдохгүй байгаа хүмүүсийн хувь 43.9 хувиар өссөн байна. 15-24 насны хүн амын 1.6 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, сургуульд сураагүй залуучууд байна.

10. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 594 иргэн тоологдож 2010 оноос 14.2 хувиар өсжээ.

ЗУРАГ 11. ГАДААДАД ОРШИН СУУГАА ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН УЛСААР, 2020 ОН



Гадаадад оршин суугаа иргэдийн ихэнхи хувь буюу 46.0 хувийг Өмнөд Солонгост ажиллахаар суурьшсан иргэд эзэлж байна. Тооллогын үед суурьших зорилгоор гадаадад оршин суугаа хүмүүсийн 25.1 хувь нь анх суралцахаар явсан байна. Харин тооллогын үед хувиараа ажиллахаар оршин суугаа хүний 37.0 хувь нь анх суралцахаар явж байжээ.

Анх суралцах зорилгоор явсан гадаадад оршин суугаа хүмүүсийн 26.0 хувь нь тооллогын үед хувиараа ажиллах зорилгоор тухайн улсдаа суурьшиж байна. Мөн анх бусад зорилгоор гадаадад оршин сууж байсан хүмүүсийн 9.0 хувь нь тооллогын үед суурьших зорилгоор гадаадад оршин сууж байна.

ЗУРАГ 12. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2020 ОН



11. СУУЦНЫ НӨХЦӨЛ

Өмнөговь аймгийн Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийт 21106 өрх тоологдсон бөгөөд хүн байнга амьдардаг 15989 сууц тоологдсон байна. Амьдарч буй өрхийн тоо, хүн байнга амьдардаг сууцны тооны харьцаа хотод ойролцоо байхад, хөдөөд өрхийн тоо нь илүү байна. Энэ нь хөдөөд нэг сууцанд олон өрхүүд хамт амьдарч байгааг харуулж байна.


ХҮСНЭГТ 8. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

	Хүн байнга амьдардаг сууц			Өрхийн тоо		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	15 989	7 008	8 981	21 106	8 200	12 906
Гэр	10 354	3 871	6 483	15 506	5 217	10 289
Байшин	5635	3137	2498	5 396	2449	5 396
Бусад сууц				204	36	168

*Орх сууцны байшингийн доторх сууцыг нэмж оруулав.

Нийт өрхийн 73.5 хувь нь монголын ард түмний уламжлалт сууц болох гэрт, 25.5 хувь нь байшинд, 1.0 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 6.6 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 6.4 пунктээр нэмэгджээ.

ЗУРАГ 12. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН



Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 13479 сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 15989 сууц тоологдсон. Харин хүн байнга амьдардаггүй илүү гэр, зуслангийн байшин 4855 тоологджээ.

ЗУРАГ 13. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Тооллогоор хүн байнга амьдардаг сууцнаас сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан. Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 76.8 хувь нь гэр сууц, 20.5 хувь нь сууцны тусдаа байшин, 0.7 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 1.5 хувь нь бие даасан тохилог сууц, 0.5 хувь нь нийтийн байр тоологдсон байна.

2020 оны тооллогоор хүн амьдрах зориулалттай 19088 сууц тоологдсон бөгөөд байнга амьдардаг орон сууц 83.8 хувийг эзэлж байна.